

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулга өгөх тухай

1. Тендерийн уламжлалт хэлбэрээр нээх бөгөөд тендерт оролцогч тендерээ Монгол, Англи хэл дээр цаасан суурьтай бэлтгэж, хуудас бүрийг гарын үсэг зурж, баталгаажуулан, эх хувиас гадна хуулбар хувиудыг тус тусад нь **“ЭХ ХУВЬ”**, **“ХУУЛБАР ХУВЬ”** гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн, тэдгээрийг дахин давхар дугтуйнд (гаднах) хийж битүүмжлэн Тендерийн барим бичгийн ТШЗ 26.1-д заасан хугацаанаас өмнө ирүүлж, ТШЗ 26.2-д заасан хаягаар ирүүлнэ. Оролцогчийн ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.

Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална. Эх хувь Монгол, Англи хэл дээр тус бүр 1 хувь, Хуулбар хувь Монгол, Англи хэл дээр тус бүр 1 хувь байна. Тендерийн pdf хуулбарыг хавсаргана (CD эсхүл USB).

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг захиалагчид тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр гаргаж болно.”, 19.2-т “Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргана.” гэж тус тус заасан. Иймд тус тендерийг 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр нээх тул тендерт оролцогчид 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс хойш ирсэн тодруулгын хүсэлтийг хүлээн авахгүй, захиалагч 19-ний өдрөөс өмнө ирсэн тодруулгад 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөрт багтаан тодруулгад хариу өгнө.

3. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүчинтэй хугацаа 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусаж, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэн баталгаажуулж байгаа тул тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.5-д “Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг холбогдох Монгол Улсын Олон Улсын гэрээг соёрхон батлах, эсхүл Засгийн газар тусгайлсан хэлэлцээрийг байгуулахаас өмнө урьдчилан зохион байгуулж болно.” гэж заасны дагуу энэ тендер шалгаруулалт урьдчилан зохион байгуулагдаж байна. Мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.7-д “Энэ хуульд зааснаар нээлттэй тендер

шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулсан бол холбогдох зээл, тусламжийн гэрээ байгуулагдах хүртэл худалдан авах гэрээ байгуулахыг хориглоно.” гэж заасны дагуу дээрх хэлэлцээр байгуулагдах хүртэл хугацаанд гэрээг байгуулах эрхгүй болно.

Иймд Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалаар баталсан Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журмын 2.5.-д “хуулийн 32.5-д зааснаар урьдчилан зохион байгуулж буй тендер шалгаруулалтад оролцогчоос тендерийн баталгааг хугацаагүйгээр гаргуулна.” гэж, Сангийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/118 дугаар тушаалаар баталсан Нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журмын 3.3.2-д “оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр батлагдах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заах;” гэж заасны дагуу тендерийн баталгааг хугацаагүйгээр, Тендер илгээх маягт 1-д тендерийг хугацаагүй хүчинтэй байхаар тусгаж ирүүлнэ.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулга хүргүүлэх тухай

“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн Увс аймгийн Улаангом суманд хийгдэх гадна ариутгах татуургын төв шугам, бохир усны насос станц, аваарын сан, биоцөөрөм шинээр барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт ирүүлсэн тодруулгад дараах хариултыг хүргүүлж байна.

Үүнд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.4-д “Тендерийн баталгааны дүнг гадаад валютаар илэрхийлсэн тохиолдолд баталгааг хөрвүүлэх ханшийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк /Монголбанк/-ны албан ханшаар тодорхойлно.” гэж заасны дагуу тендерийн баталгааны дүнг төгрөгт хөрвүүлэн ирүүлэх боломжтой.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулгад хариу өгөх тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3-т заасны дагуу “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн Увс аймгийн Улаангом суманд хийгдэх гадна ариутгах татуургын төв шугам, бохир усны насос станц, аваарын сан, биоцөөрөм шинээр барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт ирүүлсэн тодруулгад дараах хариултыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна. Иймд баталгаат орчуулгын тамга шаардлагагүй.
2. Тендерт оролцогч тендерээ Монгол, Англи хэл дээр цаасан суурьтай зааврын дагуу бэлтгэж ирүүлэхээс гадна pdf өргөтгөлтэй файлыг хавсаргана (CD эсхүл USB).
3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 2 дугаар сарны 10-ны өдрийн 36 дугаар тушаалаар баталсан “Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага батлах тухай”-ын дагуу БА-3.1-БА-3.6-д хамаарагдах заалт нь БА-4.1-БА-4.6-р заалттай адил буюу өндөр төвөгшилтэй барилга байгууламжид хамаарах тул БА 4.3-ийг БА 3.3-аар дүйцүүлж болно.
4. Иргэний хуулийн 217 дугаар зүйлийн 217.2-т “Хуулиар хориглоогүй бол талууд мөнгөн төлбөрийн үүргийг гадаадын мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэж болно.”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.4-д “Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгслэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно.” гэж заасны дагуу туслан гүйцэтгэгчийг валютын ханшийн хэлбэлзлээс хамгаалах зорилгоор түүнтэй байгуулах гэрээний валютыг “евро”-оор тооцож, үүрэг гүйцэтгэх үеийн ханшаар төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээнд тусгана.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО